

Маягт СЗХ04008

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	08	Өдөр	16
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний	Эмч, эмнэлгийн ажилтнуудын мэргэжлийн хариуцлагын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хариуцлагын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинээр батлах тухай		2021-08-16		ЗТ-21\08-019	
6	Цахимаар борлуулах эсэх	Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах	—					
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>							
9	Даатгалын зүйл	Эмч, сувилагч болон эмнэлгийн ажилтны эмчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндийн өмнө хүлээх хариуцлага					
	Даатгалын үндсэн эрсдэл	Ажил мэргэжлийн алдааг дараах нөхцөлд даатгана. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Оношлогооны явцад;</li> <li>• Эмчилгээний явцад;</li> <li>• Асаргаа сувилгааны үед;</li> <li>• Эмчилгээ, эмийн бэлдмэлийг сонгох, жор бичих явцад.</li> </ul>					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0,8% - 1,5%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

## ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Даатгуулагч даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, бүрдүүлэхээр завдсан;
2. Даатгал хийлгэх үедээ даатгалын зүйлтэй холбоотой мэдээлэл худал буюу зөрүүтэй болон даатгалын асуулгыг үнэн зөв өгөөгүй бол;
3. Даатгалын тохиолдол болсныг нотлох боломжгүй бол;
4. Даатгуулагчийн гэмт хэргийн шинж чанар, зорилготойгоор үйлдсэн үйлдлийн улмаас учруулсан аливаа хохирол;
5. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлд гарсан хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн алдагдал;
6. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээ болон даатгалын нөхцөлүүдэд тусгагдсан баримт материалыг даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хуанлийн **90** хоног дотор хүлээлгэн өгөөгүй бол;
7. Даатгуулагч даатгагчид мэдэгдэлгүй хохирлыг дур мэдэн барагдуулж хохирлын бодит үнэлгээг тогтоох, батлах боломжгүй болгосон тохиолдолд;
8. Гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна учирсан аливаа хохирол;
9. Даатгуулагч, түүний ажилтны сэтгэцийн эмгэг болон эрх зүйн чадамжгүй үед хийсэн аливаа үйлдлээс үүдсэн гарсан аливаа хохирол;
10. Даатгуулагчийн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үед хийсэн үйлдлийн улмаас үүдсэн болон энэ үед гаргасан шийдвэрийн улмаас учруулсан хохирол;
11. Байлдааны зэвсэг хэрэглэх, атомын болон цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхит цэнэгийн нөлөөгөөр үүссэн хохирол;
12. Дайн, дайны шинжтэй тэмцэл, хувьсгал, маргаан, булаан эзлэх, барьцаалах, баривчлан саатуулах, мина хаях, бөмбөг дэлбэлэх зэрэг үйл ажиллагаанаас үүдсэн хохирол;
13. Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол нийгмийн эмх замбараагүй байдал, иргэний бослого, үймээн, гэмт халдлага, террорист болон улс төрийн шинж чанартай үйл ажиллагааны улмаас үүдсэн хохирол;
14. Даатгуулагч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол;
15. Даатгалын гэрээний хугацаанд хийгдээгүй, түүнээс өмнө болон дараа хийгдсэн эмчилгээ үйлчилгээнээс үүдсэн хохирол;
16. Даатгуулагчийн бие болон сэтгэл зүйн өвчин эмгэгээс шалтгаалж учруулсан хохирол;
17. Эмнэлгийн байгууллагын тоног төхөөрөмжинд учруулсан хохирол;
18. Даатгуулагч нь эрх бүхий байгууллагын акт, дүгнэлтгүйгээр даатгалын тохиолдол бий болсныг бүрэн болон хэсэгчлэн хүлээн зөвшөөрч, ямар нэгэн төлбөр урьдчилан барагдуулсан тохиолдолд;
19. Эмчилгээ болон оношлогооны тоног төхөөрөмжийн нууц дефект, гажгаас болж гарсан хохирол;
20. Ардын уламжлалт эмчилгээ, рашаан сувилал, гоо засал, гоо сайхны эмчилгээ, үйлчилгээнээс үүдэн гарсан хохирол;
21. Даатгуулагч ажлын бус цагаар болон хувийн ашиг сонирхлын дагуу эмчилгээ үйлчилгээ хийж байх үед гарсан хохирол;
22. Даатгуулагч нь эрх мэдлээ хэтрүүлсний улмаас учруулсан хохирол;
23. Эмнэлгийн бус орчинд эмчилгээ үйлчилгээ үзүүлсний улмаас учруулсан хохирол;
24. Эмчлүүлэгч нь эмчилгээ үйлчилгээний горим, эмчийн заавар зөрчсөний улмаас учирсан хохирол;
25. Эмнэлгийн чанаргүй, баталгаагүй, хэрэглэхийг хориглосон, зөвшөөрөлгүй, хугацаа хэтэрсэн, стандартын зохих шаардлага хангаагүй эм тариа, бүх төрлийн багаж, тоног төхөөрөмж, материалыг хэрэглэсний улмаас учирсан хохирол;
26. Техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын горимыг зөрчсөнөөс үүссэн хохирол;

27. Ашиглалтын хугацаа дууссан эмнэлгийн тоног төхөөрөмжийг ашигласны улмаас учирсан хохирол;
28. Мэргэжлийн зэрэг ахиулах шалгалт өгөх, дадлага, туршилт хийх зорилгоор хийсэн эмчилгээ, үйлчилгээнээс үүдэн гарсан хохирол;
29. Үйлчлүүлэгч болон түүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалагчийн зүгээс гомдолгүй гэж баталгаа гаргасны үндсэн дээр хийгдсэн эмчилгээ үйлчилгээнээс үүдэн гарсан хохирол;
30. Хорт хавдрын IV үе шат, ДОХ зэрэг эдгэршгүй өвчнийг эмчилснээс үүдэн гарсан хохирол;
31. Эмчлүүлэгчийн өөрийн авч ирсэн, эмчилгээ үйлчилгээнд хэрэглэхийг хүссэн эм тариа, эмчилгээний бусад материалыг эмчилгээнд хэрэглэснээс үүдэн гарсан хохирол;
32. Даатгуулагчид эрх бүхий байгууллагаас өгсөн эмчлэх эрхийн бичигт зааснаас бусад төрлийн эмчилгээ хийснээс үүссэн хохирол;
33. Даатгуулагч нэг удаагийн төлөлтөөр даатгалын хураамжийг төлөх нөхцөлтэйгөөр гэрээг байгуулсан боловч хураамжаа төлөөгүй байх үед эсхүл даатгалын хураамжийг хэсэгчилж төлөх нөхцөлтэйгөөр гэрээг байгуулсан боловч гэрээнд заагдсан хуваарийн дагуу эхний төлбөрөө төлөөгүй байх үед үүссэн хохирол;
34. Хууль тогтоомж болон даатгалын нөхцөлд заасан бусад тохиолдол.